

## “ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ” ТУШААЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны 06 дугаар сарын 14

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн салбарын стратегийн худалдан авагч байгууллагын хувьд Эрүүл мэндийн даатгалын сангийн батлагдсан төсөвт багтаан, иргэн даатгуулагчдын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмнэл зүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай тусламж, үйлчилгээг худалдан авах замаар иргэн даатгуулагчдын хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах, улмаар эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогыг баримталж ажилладаг.

Стратегийн худалдан авагчийн энэхүү үндсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан тогтоол, журмуудыг мөрдлөг болгох, хэрэгжилтэд үнэлгээ хийж, тасралтгүй сайжруулах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авах, санхүүжүүлэх журам”-ын 6 дахь хэсэгт заасан удирдамжийн 2.2.2-т “Эмгэг судлалын шинжилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнээс тусад нь нэхэмжлэх ба Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхдээ Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ”-г баримтална. ЭМДЕГ-ын даргын тушаалаар жагсаалтыг батална.” гэж заасан. Уг заалтын дагуу Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 2022 оны 49/A118 дугаар тушаалаар баталсан оношилгоо, шинжилгээний жагсаалтаас энэхүү эмгэг судлалын шинжилгээний жагсаалтын төслийг боловсрууллаа.
2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 06 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан журмын 6.1-т “Амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний багцын зардлын бүрэлдэхүүнд тухайн иргэний амбулаторид хандсан шалтгааныг тодруулж, өвчний онош тогтоох зорилгоор хийгдсэн бүх төрлийн эмчийн үзлэгүүд, зөвлөгөө, эмнэлгийн нэг удаагийн хэрэгсэл, онош тогтоох, тодруулах зорилгоор хийсэн бүх оношилгоо тухайлбал дуран, компьютер болон соронзон резонанст томографын оношилгоо, тодосгогч бодис, бүх төрлийн лабораторийн шинжилгээний зардал болон холбогдох бусад зардал хамаарна.” гэж заасан. Уг амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний өртгийн бүрэлдэхүүнд тооцоологдоогүй хүртээмж бага, 2 хүртэлх эрүүл мэндийн байгууллага дээр хийгддэг эсхүл олон эрүүл мэндийн байгууллага хийдэг боловч нэг эрүүл мэндийн байгууллага ихэнх хувийг хийдэг, хэт өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ байх тохиолдлуудад эрүүл мэндийн байгууллага санхүүгийн эрсдэлд орох, мөн өртгийн тооцоололд ороогүй гэсэн шалтгааны улмаас шаардлагатай шинжилгээг хийхгүй байх, ингэснээр даатгуулагч эрүүл мэндийн хувьд хохирох нөхцөл, байдал үүссэн тул өндөр өртөгтэй зарим оношилгоо, шинжилгээний жагсаалтыг боловсрууллаа.

Энэхүү өндөр өртөгтэй зарим оношилгоо, шинжилгээний жагсаалтыг боловсруулахдаа дараах шалгуур үзүүлэлтийг хангасан оношилгоо, шинжилгээг оруулах зарчмыг баримталсан. Үүнд:

1. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 2022 оны 49/A118 дугаар тушаалаар 45,000 төгрөгөөс дээш төлбөрийн хэмжээтэй, хүртээмж бага шинжилгээ;
2. Эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны нэхэмжлэлийн мэдээлэлд хэт өндөр өртөгтэй буюу 500.000 төгрөгнөөс дээш үнэ бүхий оношилгоо, шинжилгээ хийсэн гэж гүйцэтгэл ирүүлсэн шинжилгээ;
3. Нийт нэхэмжлэлийн 70-аас дээш хувийг нэг эрүүл мэндийн байгууллага хийсэн шинжилгээ;
4. Эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны нэхэмжлэлийн мэдээлэлд гүйцэтгэл ирүүлээгүй боловч, эрүүл байгууллагууд хийхээр төлөвлөж буй 45.000 төгрөгнөөс дээш үнэтэй шинжилгээ; зэрэг болно.

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**